

## **E-Job ажлын тайлан**

2002-01-21

Улаанбаатар хот

### **E-Job ажлын товч танилцуулга:**

Одоогоос 100-аад жилийн өмнө Америкийн Нэгдсэн Улсад хэвлэгдэн гарч байсан **“Harvard Crimson”** хэмээх сониний 1898 оны 22 орчим дугаарын текстэн мэдээллийг дахин сэргээж **“XML”** хэлний tag-ыг зөв тавих явдал нь энэхүү ажлын гол зорилго байв.

Сэргээх сонингийн эхийг **“Бодь компьютер”** компаний сервер компьютерээр дамжуулан зургийн **“tif”** форматтай файлаар хүлээн авахаар тохиролцон 2001 оны 11 сарын 14-нд туршилтын журмаар 14 ширхэг файлыг хүлээн авсан болно. Сонингийн 2 нүүр нь 1 файл болж байсан бөгөөд зарын чанартай зүйлээс бусад бүх текстийг OCR болон бусад аргуудаар дахин сэргээж энгийн **“txt”** форматаар хадгалан зохих tag-уудыг тавих ёстой байлаа.

Туршилтын журмаар хүлээн авсан файлуудыг 7 компанид хувиарлан өгч гүйцэтгүүлсэн болно. Туршилтанд оролцсон компаниуд:

- **“Жэмр” ХХК**
- **“Инфокон” ХХК**
- **“И-Сервис” ХХК**
- **“Интерактив” ХХК**
- **BSB**
- **“Оргилтех” ХХК**
- **“Бодь компьютер” ХХК**

Эдгээр компаниудад эхний удаа туршилтын журмаар 2 ширхэг файлыг тус бүрт нь өгч хийлгэв.

2001 оны 12-р сарын 8-нд E-Job ажлын эхний үе шат болох 100 ширхэг файлыг хүлээн авсан болно. Файлууд нь 0001-0100 хүртэл дугаарлагдсан **“tif”** форматтай, хэмжээний хувьд: 700kb-1660kb байв. Энэ ажлыг олон нийт, их дээд сургууль, коллеж, хувийн болон төрийн хэвшлийн байгууллагуудад нээлттэйгээр зарласан бөгөөд 13 байгууллага, 3 хувь хүн оролцсон байна. Үүнд:

- **“Жэмр” ХХК**
- **“Инфокон” ХХК**
- **“И-Сервис” ХХК**
- **“Интерактив” ХХК**
- **BSB**
- **“Оргилтех” ХХК**
- **“Бодь компьютер” ХХК**
- **“Cyber” зах**
- **ШУТИС-ийн номын сан**
- **ШУА**

- **КТМС**
- **ШУМТК**
- **Үндэсний статистикийн төв газар**
- **Сэлэнгэ (хувь хүн)**
- **Тунгалагтамир (хувь хүн)**
- **Хишигтогтох (хувь хүн)**

Явцын дунд Оргилтех, BSB, Интерактив зэрэг байгууллагууд оролцож чадахгүйгээ мэдэгдсэн болно.

Е-Job ажлын гүйцэтгэгч байгууллагуудаас “Жэмр” ХХК нийт ажлын 45% буюу 45 ширхэг файлын текстийг сэргээн, tag тавьсан бөгөөд хүлээж авсан ажлаа чанарын өндөр түвшинд амжилттай гүйцэтгэснийг дурьдах нь зүйтэй болов уу.

Мөн Сэлэнгэ, Тунгалагтамир нар авсан ажлаа алдаа мадаггүй, заасан хугацаанд гүйцэтгэсэн болно. Дараа дараагийн хүлээн авах ажлын гүйцэтгэгчээр “Жэмр” ХХК, Сэлэнгэ, Тунгалагтамир нартай хамтран ажиллахад ямар нэгэн саад гарахгүй гэдэгт итгэж байна.

Харин зарим нэг байгууллагууд сониний текстийг сэргээн tag тавиагүй файл авчирч өгч байв. Үүнээс үүдэн Е-Job ажлыг хариуцагч ажилтанд tag тавигдаагүй файлуудын tag-ыг тавих давхар ажил гарч байсан нь ажлын гүйцэтгэлийг захиалагч талд товлосон хугацаанаас нилээд хойно илгээхэд хүргэсэн гэж үзэж байна. Нийт 18 файлын tag огт тавигдаагүй ирсэн байна. Үүнээс ШУМТК-ийн 5 файл, И-Сервис ХХК-ий 7 файл, BSB-ын 2 файл нийт 14 файлын tag-ыг “МИДАС” ТББ-ын ажилтан Ариунцэцэг тавьсан болно. Оргилтех ХХК-ий 2 файл, Хишигтогтохын 2 файл нийт 4 файлын tag-ыг Е-Job ажлыг хариуцагч ажилтан Тамир тавьсан байна.

Ажлын гүйцэтгэгч болох Хишигтогтохын ирүүлсэн файлуудад текстийн алдаа маш их, цөөхөн хэдэн tag тавигдсан боловч тэр нь алдаатай тавигдсан байлаа. Түүний ажлын гүйцэтгэлийг маш хангалтгүй гэж дүгнэлээ.

ШУТИС-ийн харъяа КТМС 5 файл авсан боловч удаа дараа шаардуулан 2002 оны 1-р сарын 11-нд дутуу дулимаг tag тавьсан 1 файлыг авчирч өгсөн нь шаардлага хангаагүй бөгөөд мөн Инфокон ХХК авсан 2 файлаа авчирч өгөөгүй тул КТМС-ийн 5 файл, Инфокон ХХК-ий 2 файл нийт 7 файлыг Жэмр ХХК-д шилжүүлэн гүйцэтгүүлээ.

Үндэсний статистикийн төв газар 5 файл авсан бөгөөд олон удаа шаардуулсаны эцэст гүйцэтгэж амжихгүй нь гэж мэдэгдсэн дариуд нь Сэлэнгэд тодорхой хугацаа заан шилжүүлэн гүйцэтгүүлсэн болно. Энэ бүгдээс үзэхэд Хишигтогтох, Үндэсний статистикийн төв газар, КТМС зэрэг гүйцэтгэгч байгууллагуудтай дахин хамтран ажиллахад хүндрэлтэй гэж дүгнэхэд хүргэлээ.

2002 оны 1-р сарын 15-нд Е-Job ажлын эхний үе шат 100 файлын гүйцэтгэл болох 0001-0040, 0042-0100 хүртэл дугаарлагдсан 99 ширхэг “**txt**” форматтай файлуудыг захиалагч талд илгээлээ. (40, 41-р файл ижил байв) Ажлын гүйцэтгэл болох файлуудын дундаж хэмжээ 5Kb-20Kb орчим байсан бөгөөд гэрээнд заасан ёсоор 1000 тэмдэгтийг нь 0,35\$ -оор үнэлэн (хоосон зайг тооцолгүй 330,61\$ хоосон зайг тооцон 390.87\$)-ын

### ажил гүйцэтгэлээ. (Хавсралт 1)

Ямарваа нэг ажлыг гүйцэтгэх явцад алдаа, хүндрэл гарахгүй байна гэж хараахан үгүй. Тиймээс илгээсэн файлууд дунд алдаа байгааг үгүйсгэх аргагүй юм.

### Уг ажлыг хийхэд гарч байсан зарим нэг бэрхшээлээс дурьдвал:

- Хүлээж авсан файлын 40, 41-р файлууд он сар өдөргүй байв. Үүнийг тодруулалгүй нилээд удсан.
- Файлын хэмжээ уян дискэнд багтахааргүй том учраас гүйцэтгэгчид ажлаа авч явахад их хүндрэлтэй байв.
- Захиалагч талаас жишээ болгон ирүүлсэн “txt” файлын эх “tif” файл байхгүй учир зарим нэг tag тавихад хүндрэлтэй байв.
- Гүйцэтгэгчдийн ирүүлсэн зарим нэг файлуудад текстийн алдаа маш их, сэргээсэн текст, тавьсан tag-аа хэвлэмэл эхтэйгээ дахин тулгаж үзэлгүй ирүүлсэнээс үүдэн шалгагч ажилтаны ажлыг хүндрүүлж файл илгээх хугацааг хойшлуулсаар байв.

### Дахин уг ажлыг хийхэд анхаарах зүйлс:

- Гүйцэтгэгч байгууллагуудад ажлаа тодорхой хугацаатайгаар өгөх
- Ажлын цагийн хуваарь болон гүйцэтгэгч байгууллагуудын ажлын бүртгэлийг эмх цэгцтэй, ойлгомжтойгоор хөтлөх
- Файлуудыг хэсэг хэсэг болгон хувиарлаж өгөх
- Товлосон хугацаанаас 2 хоногийн өмнө гүйцэтгэгчидтэй холбоо барин ажлын явцыг мэдэж цаашдын ажлаа төлөвлөн ажиллах
- “Бодь компьютер” компаний серверээс хамгийн хурдан бөгөөд хялбар аргыг ашиглан файлаа авах асуудлыг шийдэх
- “Интерактив” компаний бүтээсэн “XML” хэлний tag тавих, харьцуулалт хийх 2 программыг ашигладаг болох асуудлыг шийдэх
- Ажлын үнэлгээг захиалагч талтай дахин ярилцаж ахиулах тал дээр анхаарах

### Tag тавихад гарч байсан нийтлэг алдаануудаас дурьдвал:

- <>Хос tag эхлээд </> дуусахад тавидаг слэш (налуу зураас)-ыг орхих
- <Дан tag/> -д тавидаг слэш (налуу зураас)-ыг орхих
- Хуудасны он сар болон дугаарыг алдаатай тавих
- Зарим нэг tag-ыг хаахгүй орхих
- Хэдэн хэдэн текстийг нэг параграфд оруулан бичих
- <Н>Гарчгийн.</Н> төгсгөлд тавигдах ёстой цэгийг орхих гэх мэт...

Тайлан бичсэн: Б.Тамир